

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМЛЭГЛЭЛ

2021 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр

дугаар № 01

Дархан-Уул аймаг

“Дархан нэхий ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Гранд як зочид буудлын хурлын зааланд 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 12⁰⁰ цагт Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо 597 510 000 ширхэг, буюу 54,0 %-ийн ирцтэйгээр хийлээ.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. Э. Батсайхан	326 903 000 ш	5. Д. Батжаргал	10 803 000 ш
2.. Б. Дагвацэрмаа	29 087 000 ш	6. Х. Золжаргал	17 213 000 ш
3. Б. Гэрэлмаа	7 800 000 ш	8 “ННТТ” ХХК	205 704 000 ш

Хурлын дарга Х. Золжаргал, Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын даргаар Д. Ариунтуулаар ажлуулсан комисс ажиллаж байгааг танилцууллаа.

Ариунтуул: Тооллогын комиссын дарга

-Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдийн бүртгэлийг хуулийн дагуу хийж, ирцийг мэдээлж, санал өгөх зааврыг танилцуулав. Тэрээр хувьцаа эзэмшигчид энэхүү хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №1-ээр, ТУЗ-ийн гишүүдийг сонгож санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №2-оор тус тус бичгээр өгнө. Харин ТУЗ-ийн гишүүнийг сонгох санал өгөхдөө Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 09 сарын 09-ны өдрийн 880 тоот тогтоолоор шинэчлэн баталсан “Санал хураах кумулятив арга хэрэглэх журам”-ыг баримтлан санал өгнө гээд уг журмыг тайлбарлан танилцууллаа.

Хурлын дарга Х. Золжаргал:

-Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ! Та бүхний өдрийн амгаланг айлтгая.

-Тооллогын комиссын мэдээллээр хуралд оролцох Хувьцаа эзэмшигчдийн ирц 54,0%-тай байгаа тул хурлын ирцийг хангалттай гэж үзэж хурлаа эхлүүлж байна. Мөн Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг танилцуулья. Хурлын дэг ёсоор хэлэлцэх асуудлыг, асуудал тус бүрээр хэлэлцээний эцэст хувьцаа эзэмшигчид батлагдсан саналын хуудсаар саналаа өгч, тооллогын комисс эцсийн шийдвэрийг гарган дүнг танилцуулна гээд Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж үг хэлэв. Өнөөдрийн хурлаар 7 асуудлыг хэлэлцэнэ. Одоо хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулья. /Хурлын дэгийг хавсаргав/.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайланг танилцуулах
3. ТУЗ-ийн гишүүнийг сонгож батлах
4. ТУЗ-ийн төсөв батлах /цалин урамшууллын хэмжээг тогтоох/
5. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-аас гаргасан шийдвэрийг батлах
6. Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн авах тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг зөвшөөрч, батлах
7. Компани тусгаарлах, шинээр охин компани байгуулахыг батлах

Хэлэлцсэн нь:

Эхний асуудлаар: ТУЗ-ийн дарга Э. Батсайхан Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулав.

Э. Батсайхан:

-Дархан нэхий ХК-ийн 2020 оны гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн, Компанийн тухай хууль, Дархан нэхий ХК-ийн дүрмийн хүрээнд тус компанийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ээс гаргасан дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна. Дархан нэхий ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлаж, компанийн үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөөний биелэлтийг хянаж, Сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийн нийцлийг ханган биелүүлж ирлээ.

-Дархан нэхий компанийн удирдлагын баг ТУЗ-ийн баталсан 2020 оны бизнес төлөвлөгөөг цар тахалын хүнд бэрхшээлтэй нөхцөл байдал үүсэж үйлдвэрлэл борлуулалт, гадаад хангамж тасалдаж байсан ч гэсэн үйлдвэрлэлийн үйл явцад чанарын менежментийн тогтолцоо ISO-9001-г нэвтрүүлэн хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлэх, бараа бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, ажлын байрыг хадгалах, үргүй зардал гаргахгүй байх, материалын нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах бодлогыг баримтлан ажиллажээ.

-Компанийн нийт борлуулалтын орлого өмнөх оноос 8 %-иар, ашиг 12% буурсан үзүүлэлттэй гарсан боловч бараа материалын үлдэгдлийн удирдлагыг сайжруулж, материалын үлдэгдлийг 20 % бууруулж, нийт ажилтны тоог тогтвортой түвшинд байлгаж, чанар болон бүтээмжийг сайжруулахад тусгайлан анхаарч ажилласан байна.

-Дархан нэхий ХК 2020 онд 16.886 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж, бизнес төлөвлөгөөний биелэлт 37 хувь, цэвэр ашиг 1.685 тэрбум төгрөгт хүрч ашгийн төлөвлөгөө 64.3 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. 2020 онд гадаад экспортын борлуулалт бүрэн зогссон учир дотоод борлуулалтанд анхаарч ажилласан байна. Ковид цар тахалтай холбоотой борлуулалтын орлого 17%-р багасч, оны сүүлээр улс орон даяар хязгаарлалт хийсэнтэй холбоотой бараа материал үлдэгдэл өмнөх оноос 2% өссөн байна.

-Мөн тайлант жилд 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь Гранд як зочид буудлын тоног төхөөрөмж, барилга байгууламжийн тохижуулалтад зориулсан байна.

-Цар тахлын нөхцөл байдлыг харгалзан 2021 оны төлөвлөгөөг 2020 оны оны төлөвлөлтөөс бууруулж баталсан бөгөөд борлуулалт орлогыг -31% , зардлын төлөвлөлтийг -19% , ашгийн төлөвлөгөөг -51% бууруулж, үйлвэрлэлийн төлөвлөгөөг 8%-иар өсгөж бодит нөхцөл байдалтай уялдуулж бизнес төлөвлөгөөг баталсан болно.

-Цаг үеийн хүндрэлтэй нөхцөлд Дархан нэхий ХК-ийн удирдлагын баг 2020 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж, ажлын байраа хадгалан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

2-р асуудал:

КтХ-ийн 96.4-д заасан тайланг танилцуулав. /тайланг хавсаргав. /

3-р асуудал:

Х. Золжаргал: Хурлын дарга

-ТУЗ-ийн гишүүнийг сонгож, батлах асуудлыг хэлэлцье. ТУЗ-д нийтдээ 12 иргэн нэр дэвшсэн бөгөөд үүнээс ТУЗ-ийн ердийн гишүүнд 6 иргэн, хараат бус гишүүнд 6 гишүүн тус тус нэр дэвшсэн байна гээд нэр дэвшигчдийн анкет, хараат бус гишүүний шалгуурыг хангасан эсэх талаархи мэдээллийг нэр дэвшигч тус бүрээр товч танилцууллаа. ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал өгөхдөө шинэчлэн баталсан санал хураах кумулятив арга хэрэглэх журам"-ын дагуу өгөхийг дахин санууллаа. Мөн нэр дэвшигч Нэмэхийн Бэргэцэгийн материал дутуу, Засаглалын сургалтанд хамрагдсан эсэх нь тодорхойгүй, засаглалын гэрчилгээг бүрдүүлж өгөөгүйг тодотгон танилцууллаа.

Э. Батсайхан:

-Гишүүдийн анкеттай танилцлаа. Санал өгөхийн өмнө зарчмыг тохирох хэрэгтэй байна. ТУЗ дүрмээр есөн гишүүнтэй байна. Харин 9 гишүүний хэд нь ердийн, хэд нь хараат бус гишүүн байх бэ гэдгийг тогтоож ярилцъя. Ерийн гишүүн 6, хараат бус гишүүн 3 байх уу, эсвэл ердийн гишүүн 5, хараат бус гишүүн 4 байх уу.

Х. Золжаргал:

-КтХ-ын 75.4-д Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 ба түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна гэж заасан байдаг. Иймээс ердийн 5 гишүүн, хараат бус 4 гишүүнтэй байх саналыг оруулж байна.

Д. Батжаргал:

-Ердийн 5 гишүүн, хараат бус 4 гишүүнтэй байх саналыг дэмжиж байна.

Э. Батсайхан:

-Ердийн гишүүн 5, хараат бус гишүүн 4 гэсэн санал өгье.

Х. Золжаргал:

-Олонхийн саналаар Ердийн гишүүн 5, хараат бус гишүүн 4 байхаар тоог тохирлоо. Одоо дараагийн асуудалд орёё.

4-р асуудал:

ТУЗ-ийн төсвийн төслийг ТУЗ-ийн дарга Э. Батсайхан танилцуулав.

Батсайхан:

-ТУЗ-ийн дарга, 3 хороодын даргын цалин, урамшуулалд өөрчлөлт оруулах саналтай байна. Цаашид ТУЗ-ийн дарга нь аль нэг хорооны даргын ажлыг хашдаг байхаар, мөн цалинг 1000000 төгрөг болгож, хуралд оролцсоныхоо хөлсийг авч явахаар зохицуулъя. Мөн 2020 оны ТУЗ-ийн төсвийн гүйцэтгэлд бичиг хэргийн зардлыг орхигдуулснаар гүйцэтгэл дутуу гарсан байна. Үүнийг засах хэрэгтэй. Томилолтын зардлыг хасъя.

-ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг байнгын орон тоогоор ажиллуулах, 1000000 төгрөгийн цалинтай байх.

Х. Золжаргал:

-ТУЗ-ийн дарга хурал хуралдуулах боловч ТУЗ-ийн ажил зохион байгуулах, бизнесийн бодлогын хүрээнд ажлын уулзалт зохион байгуулах гэх мэт ажлууд байдаг. Аудитын хорооны даргын хурал оролцооны хөлсийг нэмэгдүүлэх нь зүйтэй байх

Д. Батжаргал:

-Хороодын дарга нарын хурал оролцооны хөлсийг 1000000 төгрөг болгох саналтай байна.

Б. Гэрэлмаа:

-Дэмжиж байна.

5-р асуудал:

Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ээс гаргасан шийдвэрийг хуралд оролцогчид санал нэгтэй дэмжлээ.

6-р асуудал:

Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн авах тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг зөвшөөрч, дэмжлээ. Гэхдээ Э. Батсайханы гаргасан Стратегийн том хувьцаа эзэмшигч гарч ирвэл охин компаниудын эргүүлэн авсан хувьцааг буцаан зарж болох нөхцөлтэйгээр нээлттэй байлгах саналыг хуралд оролцогчид санал нэгтэй дэмжив.

7-р асуудал

Компани тусгаарлах, шинээр охин компани байгуулах асуудлыг хэлэлцээд:

-Монгол улсын засгийн газрын 2018 оны Гурван тулгуурт хөгжлийн бодлого, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, компанийн тухай хууль, мөн ажиллах хүчний нөөц, гадаад дотоод эрэлт хэрэгцээ, байршил, үл хөдлөх хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор охин компани "Алтай як" ХХК-г байгуулах тухай шийдвэрийг санал нэгтэй дэмжлээ.

-Нэхий гармент ХХК-ийн гутал болон оёдлын үйлдвэрийг үйл ажиллагааны чиглэлээр нь дагнан хөгжүүлэх, өсгөж бойжуулах зорилгоор КтХ-ийн 22-р зүйлийн дагуу тусгаарласан компани байгуулах нь зүйтэй гэж үзэж санал нэгтэй дэмжлээ.

Ингээд хурлаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууссан тул хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа өгч, тус бүрийн саналын хуудсыг тооллогын комисс хүлээн авч, дүгнэн эцсийн дүнг танилцуулж, Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01, 02, 03, 04 тоот тогтоолд тусгасан шийдвэрийг тооллогын комиссын дарга Д. Ариунтуул уншиж танилцууллаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналын дүн:

1. Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайланг батлах, ТУЗ-ийн гишүүн сонгох, ТУЗ-ийн төсвийг батлах, Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-аас гаргасан шийдвэрийг батлах, мөн Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн авах тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг батлах, Компани тусгаарлах, шинээр охин компани байгуулахыг батлах шийдвэр гарсныг танилцуулав.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох саналын дүн:

Санал хураалтаар доорхи 9 гишүүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгож, үүнээс ердийн гишүүнд 5, хараат бус гишүүнд 4 гишүүн сонгогдсон тухай дүнг танилцуулав.

1. ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

1. Эрдэнэдалайн Батсайхан - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 54 хувийн саналаар;
2. Равжаагийн Сүмбэнхүү - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 54 хувийн саналаар;
3. Далхжавын Батжаргал - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 54 хувийн саналаар;
4. Хумбагийн Золжаргал - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 54 хувийн саналаар;
5. Баасангийн Гэрэлмаа - Хуралд оролцогчдын 96,8% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 52,3 хувийн саналаар

2. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

6. Бямбадашын Мөнхбаяр - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 54 хувийн саналаар;
 7. Бат-Очирын Энхнавч - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 54 хувийн саналаар;
 8. Отгоны Мөнхжаргал - Хуралд оролцогчдын 98,6% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 53,3 хувийн саналаар;
 9. Цэдэвсүрэнгийн Алтангэрэл - Хуралд оролцогчдын 95,1% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 51,4 хувийн саналаар;
- тус тус сонгогдсон байна.

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн хуралдаанаас дараах шийдвэрийг гаргалаа.

Хурлын шийдвэр:

1. Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
2. КТХ-ийн 96,4-д заасан ТУЗ-ийн тайланг батлах
3. Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
4. Дархан нэхий ХК-ийн 2021 оны ТУЗ-ийн зардлын нийт 94,9 сая төгрөгийн төсвийг батлах
5. “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ-ийн 2021 оны №02 тоот тогтоолыг батлах
6. “Өөрийн компанийн хувьцаагаа эргүүлэн авах тухай” ТУЗ-ийн 2021 оны №04 тоот тогтоолыг баталсугай. Зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан хувьцааг зөвхөн өөрийн охин компаниудаас гадна стратегийн хөрөнгө оруулагч нарт худалдаж авах боломжийг нээлттэй байлгахыг компанийн ТУЗ-д зөвшөөрөх.
7. “Алтай як” ХХК-г байгуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг батлах,
8. Компани тусгаарлах тухай компанийн тухай хуулийн 22-р зүйлийг мөрдлөг болгон тус компанийн охин компани болох оёдол, гутлын үйлдвэрлэлийн чиглэлийн Нэхий Гармент ХХК-аас гутлын үйлдвэрийг нь тусгаарлаж, үйл ажиллагааны чиглэлээр нь тусад нь дагнан хөгжүүлэх, үйл ажиллагаагаа нь төрөлжүүлэх, зах зээлд өрсөлдөх чадавхийг сайжруулах зэрэг зорилгоор тусгаарлах, тусгаарлахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх, шинээр байгуулагдах компанийн эрх, үүрэг, хариуцлагыг нь тодорхой болгож ажиллах бүрэн эрхийг Дархан Нэхий ХК-ийн ТУЗ-д олгох

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТАНИЛЦСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ХУРЛЫН ДАРГА



Х.НАРАНТУЯА

Х.ЗОЛЖАРГАЛ